



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 01 сарын 09 өдөр

Дугаар 108

Есөнбулаг сум

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.2, 50 дугаар зүйлийн 50.1.2 дахь заалт, 50 дугаар зүйлийн 50.4, 50.5 дахь хэсэг, Сангийн сайдын 2025 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн А/100 дугаар тушаалаар батлагдсан "Үнэлгээний хорооны үйл ажиллагаа, урамшууллын журам", аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 12 дугаар сарын 03-ний өдрийн 64 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн авто замын сангийн хөрөнгө оруулалтаар санхүүжигдэх Есөнбулаг сумын авто зогсоолуудыг өргөтгөх, засварлах ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга: Ш.Насан (Жангар музейн дарга)

Гишүүд: Д.Нямжаргал (Есөнбулаг сумын Засаг даргын Тамгын газрын мэргэжилтэн)
Ж.Мөнхцэцэг (Хөндлөнгийн төлөөлөл)
(тохиролцсон)

Б.Доржпалам (Есөнбулаг сумын иргэн)

Нарийн бичиг: Д.Нарандулам (Худалдан авах ажиллагааны газрын мэргэжилтэн)

2. Худалдан авах ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж, дүнг танилцуулахыг Үнэлгээний хороо (Ш.Насан)-нд үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ЧИНБАТ

